



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/316

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3 “б”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.8, Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.2.6 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхайн нөхөн сэргээлтний ажлыг эрчимжүүлэх, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжүүдэд хуулийн хариуцлага тооцуулах, ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, нөхөн сэргээгдээгүй орхигдсон газруудад нөхөн сэргээлт хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, нөхөн сэргээлт хийх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, 07 дугаар сарын 01-ний дотор аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100677

Аймгийн Засаг даргын 2021 оны 06...
дугаар сарын 28-ны өдрийн 1/31 дүгээр
захирамжийн хавсралт



**УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЛААР АВЧ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ БОЛОВСРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга: Ч.Гүнсэнхорол (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга)
- Гишүүдэд: Г.Баясгалан (Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
С.Дуламсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга)
Д.Ганцэцэг (Аймгийн Прокурорын газрын ахлах прокурор) (зөвшилцсөнөөр)
С.Дуламрагчаа (Онги, Таац голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Батзул (Аймгийн Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн мөрдөгч, Цагдаагийн ахмад)
Ц.Болдбаатар (Аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)
Ч.Бат-Өлзий (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэргэжилтэн)
Т.Очирсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч)
- Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, экологийн цагдаа, байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нар